

*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт*

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>“Улсын их дэлгүүр” ХК</p> <p>Регистрийн дугаар: 2117436</p> <p>Улсын бүртгэлийн дугаар: 9010001017</p> <p>Үнэт цаасны код: .....</p> <p>Утас: 89885120</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	<p>“Сүлд-Аудит” ХХК</p> <p>Тайлан гаргасан огноо: 2024.02.14</p>
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	36,807,850 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ</p> <p>Хянасан: Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар</p>
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>2023 онд нийт хөрөнгийн дүн 15,195.7 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 5.6 хувь буюу 846.2 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 94.4 хувь буюу 14,349.5 сая төгрөгийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 83.2%-г НӨАТ-н хувь тэнцүүлэн тооцох /690 сая/ болон бусад татварын авлага, 15.6%-г хангамжийн материал, 1.2%-г банкны харилцахын үлдэгдэл, урьдчилж гарсан зардал эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн 76.3% буюу 10,954.9 сая төгрөгийн барилга байгууламж, 23.3% буюу 3,337.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 0.2% буюу 23.1 сая төгрөгийн тавилга, компьютер дагалдах хэрэгслэл, 0,2 %</p>

		буюу 33.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт байна. 2023 оны санхүүгийн тайлан хавсаргав.
	Орлогын тайлан	2023 онд түрээсийн орлогыг 10% нэмэгдүүлэн 8,310.6 сая төгрөгийн орлоготой, 8,204.0 сая төгрөгийн зардалтай, 106.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. 2023 оны санхүүгийн тайлан хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2023 онд 106.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж оны эцсийн эзний өмчийн дүн -2,396.4 сая төгрөг байна 2023 оны санхүүгийн тайлан хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	2023 онд бүх цэвэр мөнгөн гүйлгээ -4,9 сая төгрөг, оны эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 234,811.20/төгрөгөөр/ байна. 2023 оны санхүүгийн тайлан хавсаргав.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Сонгогдсон хөндлөнгийн Аудит нь “УИД” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, “Дансны үлгэрчилсэн заавар”-ын дагуу аккруэль сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна гэж дүгнэсэн байна.	
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Улсын Их Дэлгүүр ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31ний өдрөөрхи санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгө гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Тус компани тайлант онд нийт 8,915.2 сая төгрөгийн орлого олж, 7,172.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 604.6 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлж 106.6 сая төгрөгийн ашигтай ажилласан
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 1.43 Шуурхай төлбөрийн харьцаа 1.21
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр	Улсын их дэлгүүрт гарсан галаас үүссэн хохирлын барагдуулж, барилгын засвар, сэргээн босголтыг бүрэн дуусгаж ажилласан.

	төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	УИДХК нь 2023 онд санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн гүйлгээ байхгүй.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, зээлийн хүүг хуваарийн дагуу барагдуулж байгаа
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	<p>Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Номин реалтор” ХХК-тай 2023 оны 01-р сарын 12-ны өдөр байгуулсан UID/23/1 дугаартай Түрээсийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ.</li> <li>2. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 01-р сарын 27-ны өдөр байгуулсан UID/23/3 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн барилгын дулааны узель, усны нөөцийн савны өрөөний дотор засварын ажил)</li> <li>3. “Ухаалаг эрчим хүч” ХХК-тай 2023 оны 01-р сарын 15-ны өдөр байгуулсан UID/23/4 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн 7 давхарын дотор цахилгаан, гэрэлтүүлгийн ажил)</li> <li>4. “Ухаалаг эрчим хүч” ХХК-тай 2023 оны 01-р сарын 25-ны өдөр байгуулсан UID/23/5 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн В1, 5, 7-р давхруудын агааржуулалтын системийн цахилгааны ажил)</li> <li>5. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 02-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/23/7 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн хэрэглээнэ халуун усны шугам цоорсныг 40м шланк сольж засварлах, төв хаалганд тээглүүр хийх, урсдаг шатны шилэн хаалт чангалж засварлах, 6 давхарт решотка зөөх, 1-р давхар үүдний хажуугаас үлээх усан агаар халаагч сэнсний мотор ороох, 6-р давхарын зүүн жигүүрт салбар насос тавих, цоорсон халаах хэрэгсэл солих, 7 давхарын урд хэсгийн халаалт хэвийн болгох, коллектор солих ажил)</li> <li>6. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 02-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/23/8 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн 1.5 давхарын үсчний салон дотор засал хийх, 7-р давхарын эмэгтэй АЦӨрөөнд 3 ш угаалтуур суурилуулах, 7-р давхарын халаалт хэвийн болгох PVC шугам татаж ган хоолой гагнах ажлын гэрээ)</li> <li>7. “Номин холдинг” ХХК-ийн “Номин дизайн” салбартай 2023 оны 03-р сарын 02-ны өдөр байгуулсан UID/23/11 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн гадна талбайн ногоон байгууламжийн хашлага хийх ажил)</li> <li>8. “Юнион ойл” ХХК-тай 2023 оны 05-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/23/13 дугаартай Ашиглалтын үйлчилгээний гэрээ. (Улсын их дэлгүүрийн барилгад цахилгаан хангамжийн ашиглалтын үйлчилгээ үзүүлэх)</li> <li>9. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 05-р сарын 02-ны өдөр байгуулсан UID/23/14 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн 7-р давхрын рестораны хэсгийн агаар сэлгэлт шилжүүлэх ажил)</li> <li>10. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 05-р сарын 02-ны өдөр байгуулсан UID/23/15 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн 1.5 давхарт 65 квт хэмжээтэй 3 ш чиллер суурилуулах, 2-5 дугаар давхрын агааржуулалтын төхөөрөмжрүү холбох ажил)</li> <li>11. “Номин тав трейд” ХХК-тай 2023 оны 09-р сарын 04-ний өдөр байгуулсан UID/23/21 дугаартай Ашиглалтын үйлчилгээний гэрээ. (Улсын их дэлгүүрийн барилгын талбайд)</li> </ol>	

	<p>цэвэрлэгээний ажил гүйцэтгэх)</p> <p>12. “Номин тав трейд” ХХК-ийн Харуул хамгаалалтын салбартай 2023 оны 09-р сарын 28-ны өдөр байгуулсан UID/23/20 дугаартай Харуул хамгаалалтын үйлчилгээний гэрээ. (Улсын их дэлгүүрийн барилгад харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх)</p> <p>13. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 10-р сарын 04-ний өдөр байгуулсан UID/23/23 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн төв хаалганд салхин халаагуур суурилуулах, халаалтын шугам татах ажил)</p> <p>14. “Номин мэйнтинэнс” ХХК-тай 2023 оны 12-р сарын 22-ны өдөр байгуулсан UID/23/26 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. (Улсын их дэлгүүрийн 2-7 давхрын цонхны хагарсан шилийг солих ажил)</p>
4	Цалин урамшууллын мэдээлэл
	УИДХК нь 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, НДШимтгэлд 22.8 сая төгрөг зарцуулсан байна.
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	<p>➤ “Улсын их дэлгүүр” ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хурал,</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл,</li> <li>- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга,</li> <li>- Гүйцэтгэх захирал,</li> <li>- Ахлах нягтлан бодогч,</li> <li>- Тооцооны нягтлан бодогч</li> </ul> <p>➤ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04-р сарын 28-ны өдөр хуралдаж, компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг баталсан.</li> <li>- ТУЗ-ийн хараат бус гишүүд 2023 оны 01-р сарын 03-ны өдөр хуралдаж “Номин холдинг” ХХК-ийн нэгдэлд хамаарах компаниудаас ашиглалтын үйлчилгээ авах эрх олгосон.</li> <li>- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2023 оны 01-р сарын 20-ны өдөр хуралдаж компанийн санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгосон.</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 02-р сарын 17-ны өдөр хуралдаж ТУЗ-ийн даргыг шинээр сонгох, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргах, ногдол ашиг хуваарилах эсэх, компанийн 2023 оны Бизнес төлөвлөгөөг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 03-р сарын 17-ны өдөр хуралдаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах асуудлыг хэлэлцсэн.</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 08-р сарын 09-ний өдөр хуралдаж Ажлаас чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг түр орлон ажиллах этгээдийг томилох, арилжааны банкнаас зээл авах, хөрөнгө барьцаалуулах асуудлыг хэлэлцсэн.</li> <li>- ТУЗ-ийн хараат бус гишүүд 2023 оны 09-р сарын 11-ний өдөр хуралдаж “Номин реалтор” ХХК-тай түрээсийн нэмэлт гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон.</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 09-р сарын 11-ний өдөр хуралдаж И.Галбуянг гүйцэтгэх захирлаас чөлөөлж, Х.Эрдэнэбаатарыг компанийн гүйцэтгэх захирлаар томилох,</li> </ul>

	<p>гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин хөлсийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцсэн.</p> <p>- Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 09-р сарын 28-ны өдөр хуралдаж Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны шийдвэрийг биелүүлэх асуудлыг хэлэлцсэн.</p>
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Ашиглалтын зардал хурдацтай өсөж байгаа, Улсын их дэлгүүрийн барилга насжилт өндөртэй, Ноогдол ашиг хуваарилах нөхцөл бүрдэхгүй байгаа.
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн байдлаар татан авсан Үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар компани нийт 42,920 хувьцаа эзэмшигчтэй байсан.</p> <p>2024 оны 04-р сарын 05-ны өдрийн байдлаар 5 болон түүнээс дээш хувь эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид:</p> <p>1. Р.Содном - 16,575,925 ширхэг буюу 45.03%</p> <p>2. Ш.Уламбаяр - 3,896,290 ширхэг буюу 10.6%</p> <p>3. Ш.Баярсайхан - 2,049,032 ширхэг буюу 5.56%</p>
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргаагүй.
9	Ногдол ашгийн мэдээлэл
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02-р сарын 19-ний өдрийн хурлын 24/04 дугаартай тогтоолоор 2023 оны үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Байхгүй
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Х.Эрдэнэбаатар</p> <p>Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: .....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр: .....</p> <p>Албан тушаал: “.....” ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: .....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Д.Чимгээ</p> <p>Албан тушаал: Ахлах нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг: .....</p>	
Овог, нэр: М.Өлзийбат	

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: .....